



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2019 оны 03 сарын 22 өдөр

Дугаар А/45


Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Нийслэлийн 2018 оны төсөв батлах тухай” 2018 оны 02/17 дугаар тогтоол, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 9/10 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн нутаг дэвсгэрт гадна зар сурталчилгаа байрлуулахад дагаж мөрдөх журам”-ын 7 дугаар зүйлийн 7.1.4, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам”-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2019 оны А/09 дүгээр тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны 01 дүгээр зөвлөмжийн дагуу “Нийслэлийн нутаг дэвсгэрт гадна зар сурталчилгаа байрлуулахад дагаж мөрдөх журам”-ын тавигдах шаардлагыг зөрчсөн гадна зар сурталчилгааны байгууламжийг албадан буулгах ажлыг гэрээний хүрээнд зохион байгуулж, гүйцэтгэлд хяналт тавьж, явц үр дүнг тайлагнан ажиллахыг Төхижилт, хог хаягдлын удирдлагын хэлтэс /Г.Ууганбаяр/-т үүрэг болгосугай.

2. Дээрх ажилд шаардагдах 25,000,000 /Хорин таван сая/ төгрөгийг Улаанбаатар хот нийтийн аж ахуй тохижилт үйлчилгээний зардлаас санхүүжүүлэхийг Ахлах нягтлан бодогч /Б.Цэрмаа/-д зөвшөөрсүгэй.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР

